



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/88

Сүхбаатар сум

Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5."а", 29.1.5 "г", Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 15 дугаар зүйлийн 15.12.2, 15.12.4, 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.1, 19.3.3, 19.3.5, 19.14.3, 19.17, 19.20.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах аж ахуй нэгж байгууллагын жагсаалтыг хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх аж ахуй нэгж байгууллагын захирал, дарга нарт "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр"-ийн 3.2.1.5, 3.2.2.2 дахь заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.


3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү /-д нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2019 оны 03-р сарын 20-ны өдрийн
А/88 тоот захирамжийн нэгдүгээр хавсралт



Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах байгууллагууд

№	Байршил	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн чиглэл	Олгох хугацаа
Эмийн сан				
1	Сүхбаатар сум	“Буянтрашаан-1” хувийн эмийн сан	Үйл ажиллагаа эрхлэх	3 жил
2	Сүхбаатар сум	“Буянтрашаан-3” хувийн эмийн сан	Үйл ажиллагаа эрхлэх	3 жил
3	Зүүнбүрэн сум	“Бүрэн тун” хувийн эмийн сан	Үйл ажиллагаа эрхлэх	3 жил
4	Ерөө сум	Эрүүл мэндийн төвийн эмийн сан	Үйл ажиллагаа эрхлэх	2 жил
5	Мандал сум Түнхэл тосгон	Эрүүл мэндийн төвийн эмийн сан	Үйл ажиллагаа эрхлэх	2 жил
6	Мандал сум	“Энхийн тун” хувийн эмийн сан	Үйл ажиллагаа эрхлэх	2 жил
7	Сайхан сум Номгон тосгон	Эрүүл мэндийн төвийн эмийн сан	Мансууруулах эмээр үйлчлэх эрх	1 жил
8	Ерөө сум Бугант тосгон	Эрүүл мэндийн төвийн эмийн сан	Үйл ажиллагаа эрхлэх	6 сар
Эрүүл мэндийн төв				
1	Ерөө сум Бугант тосгон	Эрүүл мэндийн төв	Үйл ажиллагаа эрхлэх	6 сар
Эмнэлэг				
1	Сүхбаатар сум	“Итгэлт Ачтан” уламжлалтын хувийн эмнэлэг	Үйл ажиллагаа эрхлэх	3 жил
2	Мандал сум	“Мишээл дент” хувийн шүдний эмнэлэг	Үйл ажиллагаа эрхлэх	6 сар
Сувилал				
1	Мандал сум Түнхэл тосгон	“Түнхэл” сувилал	Үйл ажиллагаа эрхлэх	3 жил